



СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024. 10. 30 № А-1/4106
танай _____-ны № _____-т

**Тодруулгын хариу хүргүүлэх
тухай**

Тус газраас зарласан ЭЗХЯ/20240103166 дугаартай “Баянхонгор аймгаас Архангай аймгийн Хангайн сумд хүртэлх 350 км хатуу хучилттай автозамын ТЭЗҮ, зураг төсөл /Баянхонгор/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

№	Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1	Ажлын даалгаварт тусгагдсаны дагуу зураг төсөл зохиох үе шат, хугацаа нь 2024-2025 он гэж заасан байна. Ажил гүйцэтгэх хугацаа нь 2025 он бүтэн хамаарч байгаа эсэх, эсвэл ажил гүйцэтгэх тодорхой сар, өдөр тендерийн баримт бичигт байгаа эсэх.	Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-ийн “5. Бусад шаардлага: Шаардана. Ажлын даалгаврын дагуу ажлын төлөвлөгөө, графикийг боловсруулахдаа 90 хоногт багтаан гүйцэтгэхээр төлөвлөсөн байх” гэж нэмж тусгав. Худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-д тус өөрчлөлтийг тусгасан ба тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан тул холбогдох өөрчлөлтийг өөрийн тендерт тусган ирүүлнэ үү.
2	Дээрх үйлчилгээний ажлын тендер сонгон шалгаруулалтын тендерийн баримт бичгийн ТШЗ 25.5-д оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалтыг заасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2-д тусгагдсан заалтыг бүрэн хангах эсэх талаар тус тус тодруулга авах хүсэлтэй байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээнэ. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ. Тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 25.5-д заасан болно.

Худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан тул холбогдох өөрчлөлтийг өөрийн тендерт тусган ирүүлнэ үү.

ДАРГА 

9020020105 СБТ & 11261 6529909

Ц.БАТЗУЛ

132402010937